



“МОНГОЛПРОСЦВЕТМЕТ”
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН
ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn
Вэбсайт: www.mof.gov.mn

2023.03.06 № 03/1241

танай _____-ны № _____-т

Гомдол хянасан тухай

Танай байгууллагаас зарласан МРЦМ/202312425 дугаартай “Дизель түлш” нийлүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтын 1 дүгээр багцад оролцсон “Сод Монгол групп” ХХК-аас гаргасан гомдлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсэг болон Сангийн сайдын 2019 оны 131 дүгээр тушаалаар баталсан “Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам”-д заасны дагуу захиалагчаас ирүүлсэн холбогдох баримт материалд үндэслэн хянан үзлээ.

“Сод Монгол групп” ХХК-ийн гомдолд захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Шунхлай трейдинг” ХХК нь “Шунхлай” ХХК-ийн шатахуун импортлох тусгай зөвшөөрөл ирүүлсэн, ижил төстэй бараа нийлүүлсэн талаарх мэдээлэлд “Шунхлай говь” ХХК, “Шунхлай петролиум” ХХК-ийн баримтууд ирүүлсэн, “Мезом” ХХК-д шатахуун нийлүүлсэн мэдээллийг Маягт 7-ийн дагуу ирүүлээгүй зэрэг нь тендерийн баримт бичгийн тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 18.6.1, ТШЗ 18.6.4-д заасан шаардлага хангахгүй байх тул хянан үзэхийг хүссэн байна.

Гомдолд дурдсаны дагуу захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Шунхлай трейдинг” ХХК-ийн ирүүлсэн тендерийг хянан үзлээ.

1. “Шунхлай трейдинг” ХХК-ийн тендерт “Мезом” ХХК-тай 2022 онд байгуулсан Т/618 дугаар гэрээний мэдээллийг хүснэгтээр ирүүлсэн нь тендерийн баримт бичгийн Маягт 7-д заасан ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээллийн шаардлагад нийцсэн гэж үнэлгээ хийсэн захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байна.

2. Тендерийн баримт бичгийн тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 18.6.1-д “Тусгай зөвшөөрөл шаардана. Бүх төрлийн шатахуун, шингэрүүлсэн шатдаг хий импортлох болон бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл” гэж заасан байна.

Үнэлгээний хорооны дүгнэлтээс үзэхэд “Шунхлай трейдинг” ХХК нь тендертээ гомдолд дурдсан “Шунхлай” ХХК-ийн шатахуун импортлох тусгай зөвшөөрөл ирүүлсэн нь тендерийн баримт бичгийн дээрх заалтад нийцэх эсэхэд үнэлгээ хийгээгүй байна.

3. Түүнчлэн тус компанийн тендерт ирүүлсэн “Шунхлай говь” ХХК, “Шунхлай петролиум” ХХК-ийн ижил төстэй ажлын мэдээллүүд нь тендерийн баримт бичгийн тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 18.6.4-т “...Туршлагыг нотлох зорилгоор ижил

9766002818

төстөйд хамааралтай гэрээ, үйлчлүүлэгчийн тодорхойлолт эсхүл гэрээ дүгнэсэн актын эх хувиас татсан хуулбар. Тухайн гэрээтэй холбоотой борлуулалт хийгдсэнийг нотлох бараа, ажил, үйлчилгээний НӨАТ-ын баримтыг ирүүлнэ.” гэж заасан шаардлагад нийцэх эсэхэд мөн үнэлгээ хийгээгүй байна.

Иймд захиалагчийн 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 1/408 тоот гэрээ байгуулах эрх олгосон шийдвэрийг хуулийн 55 дугаар зүйлийн 55.3.1 дэх заалтыг үндэслэн хүчингүй болгон шийдвэрлэж байна.

Тендер шалгаруулалтын үнэлгээг хууль, журамд нийцүүлэн дахин хийхийг хуулийн 55 дугаар зүйлийн 55.3.3 дахь заалтад үндэслэн мэдэгдье.

Хуулийн 55 дугаар зүйлийн 55.4 дэх хэсэгт заасны дагуу захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг түр түдгэлзүүлсэн шийдвэрийн хугацаа үүгээр дуусгавар болно

Хувийг: “Сод Монгол групп” ХХК-д.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



Ж.ГАНБАТ